



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2016 оны 09 сарын 16 өдөр

Дугаар A/131

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"ШУТИС-ийн дурэм"-ийн 4.12.14, Ректорын зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталж, 2016 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс мөрдсүгэй.
2. Батлагдсан журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, мониторингийн газрын дарга /Л.Пүрэв/, Багшийн хөгжлийн төвийн захирал /Т.Уранчимэг/, бүрэлдэхүүн сургууль, институтын захирлуудад даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ректорын зөвлөлийн 2008 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцэн баталсан "ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Б.ОЧИРБАТ




ШУТИС-ИЙН ОНЫ ШИЛДЭГ БАГШ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь ШУТИС-ийн эрдмийн хамт олныг хөгжлийн алсын хараа, эрхэм зорилгод нэгтгэж, чадварлаг манлайлагч баг болгон төлөвшүүлэх, багш бүрийн тасралтгүй сурч, хөгжих үйл ажиллагааг дэмжин, сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний чанарыг сайжруулах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж, урамшуулахтай холбогdon үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Профессор багш нарын ажлыг сургалт, эрдэм шинжилгээ судалгаа, зөвлөх үйлчилгээ, хувь хүний хөгжил гэсэн гурван үндсэн чиглэлээр шалгаруулах бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг журмын хавсралтаар тогтооно.
- 1.3 ШУТИС-ийн цалингийн сүлжээгээр цалинждаг профессор багш нарын ажлын үр дүнг дараах ангилалаар шалгаруулна. Үүнд:
 - **ШИЛДЭГ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ БАГШ**
Боловсролын шинэчлэлд манлайлан оролцдог, идэвхтэй сургалтын арга технологиудын чиглэлээр судалгаа хийж, сургалтандaa нэвтрүүлдэг, оюутны хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол санаачлан явуулдаг, багшлах ур чадварын туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлдэг, мэргэжлийн ёс зүйтэй сурган хүмүүжүүлэгч багш байна.
 - **ШИЛДЭГ СУДЛААЧ БАГШ**
Эрдэм судлалын ажлаараа дотоод, гадаадад танигдан сургуулийн нэр хүндийг өсгөх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд санаачлагатай ажилладаг, залуу судлаачдыг дагалдуулан удирддаг, судалгааны ажил нь практикт нэвтэрсэн, судлаач, эрдэмтэн багш байна.
 - **ШИЛДЭГ ЗАЛУУ БАГШ**
Багш мэргэжлийн ёс зүйг эзэмшсэн, харилцааны соёлтой, сурган хүмүүжүүлэх арга зүйд ахмад багш нараас суралцдаг, мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэгээ тогтмол хөгжүүлдэг, нийгэм хамт олны ажилд идэвхтэй оролцдог, санаачлагатай, 3-8-н жил багшилсан залуу багш байна.
 - **ШИЛДЭГ ЗӨВЛӨХ БАГШ**
Зөвлөсөн оюутнуудынхаа хүмүүжил, төлөвшилд анхааран ажилладаг, оюутныг өөрийгөө нээн хөгжүүлэх, мэргэжлээ таньж, дур сонирхолтой болоход нь чиглэсэн ажлуудыг санаачлан хийдэг, даасан анги нь сурлага хүмүүжил, урлаг спорт, олон нийтийн ажлаараа бусдаасаа ялгарсан тэргүүний, оюутны туслагч, зөвлөгч багш байна.
 - **ШИЛДЭГ БҮТЭЭЛЧ БАГШ**
Инновацийн шинэ бүтээл, бүтээгдэхүүн гаргаж, онцгой санаагаа хэрэгжүүлэн практикт нэвтрүүлдэг, өөрийн уран бүтээл, урлаг, спортын өндөр амжилтаараа дотоод, гадаадад танигдсан, шинийг санаачлагч, хамт олныг манлайлагч багш байна.

Хоёр. Шалгаруулалтын зохион байгуулалт

- 2.1 Оны шилдэг багш шалгаруулах үйл ажиллагаа нь хоёр үе шаттай явагдах бөгөөд эхний шатны шалгаруулалт нь бүрэлдэхүүн сургууль институт дээр,



- хоёрдугаар шатны шалгаруулалт нь ШУТИС-ийн хэмжээнд нээлттэй өдөрлөг хэлбэрээр зохион байгуулагдана.
- 2.2 Шалгаруулалтанд оролцох багш нарын бүтээл нь өмнөх хичээлийн жилд хамарагдах, ШУТИС-ийн ном сурх бичиг бичихэд тавигдах үндсэн шаардлагыг хангасан байна.

Шалгаруулалтын комисс:

- 2.3 Эхний шатны шалгаруулалтыг тухайн бүрэлдэхүүн сургууль, институтын захирлаар ахлуулсан багшийн хөгжлийн багийн ахлагч, нэр хүнд бүхий эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнийг бүрэлдэхүүн сургууль, институтийн захирлын тушаалаар батална.
- 2.4 Хоёрдугаар шатны шалгаруулалтыг холбогдох асуудал эрхэлсэн проректор, багшийн хөгжлийн төвийн захирал, багш, сургуулийн нэр хүнд бүхий эрдэмтэн багш нарыг оролцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй ангилал тус бүрт байгуулагдсан комисс шалгаруулна. Комиссын бүрэлдэхүүнийг Ректорын тушаалаар батална.

Шалгаруулах үйл явц:

- 2.5 Профессор багш нар энэхүү журмын хавсралтанд заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр бүтээлээ дүгнэн, холбогдох баримт материалыа шалгаруулалтын комисст хүргүүлнэ.
- 2.6 Профессор багш нараас ирсэн материалыг шалгаруулалтын комисс дүгнэн оноог гаргах бөгөөд хамгийн өндөр оноотой нэг багш тухайн ангилалдаа шилдгээр тодорч бүрэлдэхүүн сургууль, институтийн шилдэг багшаар нэрлэгдэнэ.
- 2.7 Эхний шатны шалгаруулалтын комисс бүрэлдэхүүн сургууль, институтын шилдэг багшаар шалгарсан багшийн материалыг үнэлгээний хамт хоёрдугаар шатны шалгаруулалтын комисст ирүүлнэ.
- 2.8 Хоёрдугаар шатны шалгаруулалтанд бүрэлдэхүүн сургууль институтээс шилдгээр шалгарсан багш нар бүтээлээрээ үзэсгэлэн гаргаж, шалгуур үзүүлэлтийн дагуу илтгэл тавьж оролцоно. Шалгаруулалтын комисс ирсэн материалыг шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэнэ.
- 2.9 Багш нарын илтгэлд шалгаруулалтын комиссын гишүүн бүр 30 хүртэлх оноог өгөх бөгөөд онооны дундажаар илтгэлийн оноо гарна. Шалгуур үзүүлэлт болон илтгэлийн онооны нийлбэрээр хоёрдугаар шатны шалгаруулалтын оноог дүгнэнэ.
- 2.10 Нэг болон хоёрдугаар шатны онооны нийлбэрийн дундажаар ангилал бүрт эхний гурван байрыг шалгаруулж ШУТИС-ийн оны шилдэг багшийг тодруулна.
- 2.11 Шалгаруулалтын явцад гарах санал, хүсэлтийг шалгаруулалтын комисс хүлээн авч шийдвэрлэх бөгөөд шалгаруулалтын комиссын шийдвэр эцсийнх байна.

Гурав. Шагнал урамшуулал

- 3.1 Бүрэлдэхүүн сургууль, институтийн хэмжээнд шилдэг багшаар шалгарсан багш нарыг бүрэлдэхүүн сургууль, институтийн захирлын тушаалаар баталгаажуулж, нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгоно.

- 3.2 ШУТИС-ийн хэмжээнд оны шилдэг багшаар шалгарсан багш нарыг ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталж, мэргэжлээ дээшлүүлэх, судалгааны ажлаа хөгжүүлэхэд нь зориулж шагналын грант олгоно.
- Нэгдүгээр байр: Оны шилдэг багш өргөмжлөл, 5 сая төгрөгийн грант
 - Хоёрдугаар байр: Оны шилдэг багш өргөмжлөл, 3 сая төгрөгийн грант
 - Гуравдугаар байр: Оны шилдэг багш өргөмжлөл, 2 сая төгрөгийн грант
- 3.3 Бүрэлдэхүүн сургууль, институтийн Оны шилдэг багшаар шалгарсан багш ШУТИС-ийн хэмжээнд байр эзэлсэн тохиолдолд журмын 3.1-д заасан шагналыг давхардуулан олгохгүй.
- 3.4 Оны шилдэг багшаар шалгарсан багш нарын ажлын туршлагыг хичээлийн жилийн турш багшийн хөгжлийн төвийн вэб сайт болон нийгмийн сүлжээгээр сурталчилж, нийт багш нарт түгээнэ.

ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах
журмын нэгдүгээр хавсралт

ОНЫ ШИЛДЭГ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ БАГШ шалгаруулах узүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Авах тоо	Тайлбар
Нэг. Сургалтын үйл ажиллагаа			
1.1. Сургалтын хөтөлбөр боловсруулсан байдал			
Шинэчлэн боловсруулсан			
Боловсруулахад оролцсон	1 хөтөлбөр	15	
Хөтөлбөр магадлан итгэмжлүүлсэн		10	
1.2. Үзүүлэх, нээлттэй хичээл заасан, идэвхитэй сургалтын арга хэрэглэсэн байдал			
ШУТИС-ийн хэмжээнд		40	
Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд	1 хичээл	30	
Салбар, тэнхимийн хэмжээнд		20	
Идэвхтэй сургалтын аргуудыг сургалтанд хэрэглэсэн		25	
1.3. Цахим хичээл шинээр боловсруулсан	1 иж бүрдэл	35	
1.4. Дадлага удирдсан	1 оюутан	2	
1.5. Залуу багшийг дагалдуулан дадлагажуулсан	1 багш	15	
1.6. Мэргэжлийн хичээлийн олимпиад, тэмцээн зохион байгуулсан	1 ажил	10	
1.7. Шинэ лаборатори, кабинет байгуулахад оролцсон	1 лаб	5	
1.8. Удирдсан оюутан			
Доктор		20	
Магистр	1 оюутан	15	
Бакалавр		5	
1.9. Мэргэжлийн болон сурган заах арга зүйн бүтээл хэвлүүлж эргэлтэд оруулсан байдал			
Сурах бичиг		10	
Орчуулгын бүтээл		5	
Бодлого, дасгалын хураамж	1х.х.	4	
Гарын авлага, арга зүйн зөвлөмж		2	
Хянан тохиолдуулсан		1	
Номын хэрэглээ, эргэлтэд орсон	1 эргэлт	1	Бүтээл бүр дээр ШУТТНС-н тодорхойлолт
Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, төсөл гэрээт ажил			
2.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл			
IF-тай сэтгүүлд		15	
Мэргэжлийн хянаагдаг сэтгүүлд	1 өгүүлэл	10	
Олон улс, үндэсний хэмжээний хурлын эмхэтгэлд		8	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хурлын эмхэтгэлд		4	
Олон улсын, үндэсний хуралд		6	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хуралд	1 илтгэл	3	
Зайнаас оролцсон		2	
2.2. Төсөл, гэрээт ажилд оролцсон	1 ажил	2	
2.3. Эрдмийн зэрэг, цол ахисан			
PhD	хамрагдах	30	
Профессор, Дэд профессор	хугацаанд	20	
Гурав. Зөвлөх үйлчилгээ, хувь хүний хөгжил			
3.1 Зөвлөсөн оюутан завсардалгүй курсан $\frac{\text{ХУЗОТ}}{\text{НУЗОТ}} > 0,8$ энд, НУЗОТ- Намрын улиралд зөвлөсөн оюутны тоо, ХУЗОТ-Хаврын улиралд зөвлөсөн оюутны тоо	0,8-аас дээш	20	Сонголт 1,2-ын нэгтгэлээр
3.2 Зөвлөсөн оюутны үнэлгээний голч дүн, сургуулийн үнэлгээний дунгийн голчоос дээш байх	СҮГД-с дээш	15	СҮГД-Сургуулийн үнэлгээний голч дүн
3.3 Олимпиадад оюутан нь амжилт гаргасан байдал			
Олон улс, үндэсний хэмжээнд	1 оюутан	20	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд		10	
Оюутны ЭШХ-д оюутан удирдаж оролцуулсан		6	
3.4 Оюутны хүмүүжил, төлөвшлийн ажилд оролцсон, зохион байгуулсан		8	
3.5. Нийтэд лекц үншсан, клуб дүгүйлан удирдсан, олон нийтийн ажилд оюутан удирдан оролцуулсан	1 ажил	6	ОХЯ-ны тодорхойлолт
3.6. Нийгмийн туст хөдөлмөрт оюутнаа хамруулсан		5	
3.7. Сурган заах арга зүй, мэргэжлийн сэтгүүлийн зөвлөлийн гишүүнчлэл	1 зөвлөл	10	

ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах
журмын хоёрдугаар хавсралт

ОНЫ ШИЛДЭГ СУДЛААЧ БАГШ шалгаруулах үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Авах тоо	Тайлбар
Нэг. Сургалтын үйл ажиллагаа			
1.1. Лаборатори шинээр байгуулах	1 лаб	30	
1.2. Идэвхтэй сургалтын аргуудыг сургалтанд хэрэглэсэн	1 хичээл	10	Дэд захирлын тодорхойлолт
1.3. Сургалтын хөтөлбөр шинээр боловсруулахад оролцсон	1 хөтөлбөр	5	
1.4. Залуу судлаачийг дагалдуулан ажилласан Төсөл, гэрээт ажил дээр хамтарсан	1 судлаач	4	
1.5. Удирдсан оюутан			
Доктор	1 оюутан	20	
Магистр		5	
1.6. Судалгааны ажлаас сургуульд оруулсан хувь нэмэр	100 мян, төг. тутамд	5	
1.7. Нэг сэдэвт бүтээл, ном сурах бичиг хэвлүүлж, эргэлтэд оруулсан байдал			
Нэг сэдэвт бүтээл		10	
Ном, сурах бичиг, дангаараа хамтарсан		5	
Хянан тохиолдуулсан	1 х.х.	2	
Цахим ном		2	
Номын хэрэглээ, эргэлтэд орсон	1 эргэлт	1	Бүтээл бүр дээр ШУТТНС-н тодорхойлолт
Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, төсөл гэрээт ажил			
2.1. ЭШӨ, хураангуй бичиж хэвлүүлсэн, илтгэл тавьсан			
IF-тай сэтгүүлд		50	Хамтын бүтээлд 1-р зох. онооны 50%, 2-р зох. 30%, 3-р зох. 20% 4 ба бусад
Мэргэжлийн хянаагдаг сэтгүүлд	1 өгүүлэл	10	
Олон улс, ундэсний хэмжээний хурлын эмхэтгэлд		15	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хурлын эмхэтгэлд		5	
Олон улс, ундэсний хэмжээний хуралд	1 илтгэл	10	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хуралд		5	
Зайнаас оролцсон		5	
2.2. Өгүүлэл нь олон улсын бүтээлүүдэд ишлэгдсэн	1 ишлэл	15	Эхний 3-н зохиогчийн нэг байх
2.3. Шинэ бүтээлийн гэрчилгээ авсан	1 гэрчилгээ	80	
2.4. Төслийн удирдагч оролцогч	1 төсөл	10	
		5	
2.5. Эрдмийн зэрэг, цол ахисан			
ScD	хамрагдах хугацаанд	50	
PhD, Профессор		30	
Дэд профессор		10	
Гурав. Зөвлөх үйлчилгээ, хувь хүний хөгжил			
3.1. Зөвлөсөн оюутан завсардалгүй сурсан $\frac{\text{ХУЗОТ}}{\text{НУЗОТ}} > 0.8$ энд, НУЗОТ- Намрын улиралд зөвлөсөн оюутны тоо, ХУЗОТ-Хаврын улиралд зөвлөсөн оюутны тоо	0,8-аас дээш	20	Сонголт 1, 2-ын нэгтгэлээр
3.2. Оюутны ЭШХ-д оюутан удирдаж оролцуулсан	1 оюутан	10	
3.3. Мэргэжлийн байгууллага, зөвлөлийн гишүүнчлэл			
Олон улсын	1 зөвлөл	15	
Улс, их дээд сургуулиудын		10	
Бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхим, мэргэжлийн сэтгүүлийн редакцийн		5	
3.4. Гадаад дотоодын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан байдал			
Гадаадад зохион байгуулсан	1 арга	15	
Дотоодод зохион байгуулсан	хэмжээ	10	
3.5. Багшийн хөгжил, олон нийтийн ажил			
Багшийн хөгжилд чиглэсэн	1 ажил	10	
Нийтэд мэдлэг түгээхэд чиглэсэн		5	


ОНЫ ШИЛДЭГ ЗАЛУУ БАГШ шалгаруулах үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Авах оноо	Тайлбар
Нэг. Сургалтын үйл ажиллагаа			
1.1 Хичээлийн файл бүрдүүлэлт, багшийн вэб хөтөлбөт			
Хичээлийн файл бүрдэлт	1 хичээл	40	
Багшийн вэб хөтөлбөт		20	
Хөтөлбөр магадлан итгэмжлүүлсэн	1 хөтөлбөр	10	
1.2. Үзүүлэх, нээлттэй хичээл заасан байдал, идэвхитэй сургалтын арга хэрэглэсэн байдал			
ШУТИС-ийн хэмжээнд		30	
Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд		20	
Салбар, тэнхимийн хэмжээнд	1 хичээл	15	
Идэвхтэй сургалтын аргуудыг сургалтанд хэрэглэсэн		20	
1.3. Бодлогын хураамж, лабораторийн ажлын заавар, гарын авлага боловсруулж хэвлүүлсэн, зргэлтэд оруулсан байдал			
дангаараа		8	
хамтарсан	1 х.х.	5	
Хэвлэлийн эх бэлтгэл		1	
1.4 Ахмад багшийн хичээлд сусан	Протокол	10	
1.5 Цахим хичээл боловсруулсан	1 иж бүрдэл	30	
1.6 Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцсон	1 хөтөлбөр	5	
1.7 Номын хэрэглээ, зргэлтэд орсон	1 эргэлт	1	Бүтээл бүр дээр ШУТТНС-н тодорхойлолт
1.8 Лаборатори шинээр байгуулахад оролцсон	1 лаб	15	
1.9. Үйлдвэрлэл дээр тодорхой чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн, дадлага хийсэн	1 дадлага	20	Дадлагын тайлан
Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, төсөл гэрээт ажил			
2.1. ЭШӨ, хураангуй бичиж хэвлүүлсэн, илтгэл тавьсан			
IF-тай сэтгүүлд		20	
Мэргэжлийн хянагдаг сэтгүүлд		10	
Мэргэжлийн сэтгүүлд	1 өгүүлэл	5	
Олон улс, үндэсний хэмжээний хурлын эмхэтгэлд		10	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хурлын эмхэтгэлд		5	
Олон улс, үндэсний хэмжээний хуралд		15	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хуралд	1 илтгэл	10	
Зайнаас оролцсон		5	
2.2. Төсөл, гэрээт ажилд оролцсон	1 төсөл	10	
2.3. Докторын зэрэг хамгаалсан	хамрагдах хугацаанд	35	
Гурав. Зөвлөх үйлчилгээ, хувь хүний хөгжил			
3.1. Зөвлөсөн оюутан завсардалгүй сурсан $\frac{\text{ХУЗОТ}}{\text{НУЗОТ}} > 0,8$	0,8 дээш	20	Сонголт 1, 2-ын нэгтгэлээр
энд, НУЗОТ- Намрын улиралд зөвлөсөн оюутны тоо, ХУЗОТ-Хаврын улиралд зөвлөсөн оюутны тоо			
3.2. Оюутны ЭШХ-д оюутан удирдаж оролцуулсан	1 оюутан	15	
3.3. Олимпиад уралдаан тэмцээнд оюутан оролцуулсан		10	
3.4. Оюутны хүмүүжил, төлөвшлийн арга хэмжээ зөхион байгуулсан	1 ажил	10	OXYA-ны тодорхойлолт
3.5. Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлсэн байдал			
TOEFL-н оноо 550-аас дээш	гэрчилгээ	30	
Олон улсын шалгалтын оноо	75% дээш	10	
Хэлний сургалтанд хамрагдсан	1 сургалт	5	
3.6. Багшийн хөгжлийн хөтөлбөрийн биелэлт			
Шууд удирдлагын үнэлгээ		10	
Багшийн хөгжлийн үнэлгээ	Тодорхойлолт	10	БХБ-ийн ахлагчийн тодорхойлолт
3.7. Сурган заах арга зүйн сургалтанд хамрагдсан	Гэрчилгээ	5	

ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах
журмын дөрөвдүгээр хавсралт

ОНЫ ШИЛДЭГ ЗӨВЛӨХ БАГШ шалгаруулах үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	ОНОО	Тайлбар
Нэг. Сургалтын үйл ажиллагаа			
1.1. Сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцсон	1 хөтөлбөр	10	
1.2 Хөтөлбөр магадлан итгэмжлэлд оролцсон		5	ТАТЫН 1-9097087
1.3. Мэргэжлийн ном сурах бичиг хэвлүүлж, эргэлтэд оруулсан байдал			
Сурах бичиг, ном бичихэд оролцсон		2	
Бодлого, дасгалын хураамж, дангаараа		5	
хамтарсан	1х.х.	2	
Гарын авлага, дангаараа		5	
хамтарсан		2	
Хянан тохиолдуулсан		1	
1.4. Номын хэрэглээ, эргэлтэд орсон	1 эргэлт	1	Бутээл бүр дээр ШУТТНС-н тодорхойлолт
1.5. Цахим хичээл шинээр боловсруулсан	1 иж бүрэн	25	
1.6. Идэвхтэй сургалтын аргуудыг сургалтанд ашигласан	1 хичээл	15	Дэд захирлын тодорхойлолтоор
1.7. Дадлага удирдсан	1 оюутан	2	
1.8. Удирдсан оюутан			
Магистр	1 оюутан	15	
Бакалавр		10	
Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, төсөл гэрээт ажил			
2.1. ЭШӨ, хураангуй бичиж хэвлүүлсэн, илтгэл тавьсан байдал			
IF-тай сэтгүүлд		15	
Мэргэжлийн хянаагдаг сэтгүүлд		9	
Мэргэжлийн сэтгүүлд	1 өгүүлэл	4	
Олон улс, үндэсний хэмжээний хурлын эмхэтгэлд		6	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хурлын эмхэтгэлд		4	
Олон улс, үндэсний хэмжээний хуралд		6	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хуралд	1 илтгэл	2	
Зайнаас оролцсон		2	
2.2 Төсөл, гэрээт ажилд оролцсон	1 төсөл	2	
Эрдмийн зэрэг хамгаалсан PhD	хамрагдах хугацаанд	50	
Гурав. Зөвлөх үйлчилгээ, хувь хүний хөгжил			
3.1 Зөвлөсөн оюутан завсардалгүй курсан $\frac{ХУЗОТ}{НҮЗОТ} \geq 0,8$	0,8-аас дээш	40	Сонголт 1,2-ын нэгтгэлээр
энд, НҮЗОТ- Намрын улиралд зөвлөсөн оюутны тоо			
ХУЗОТ-Хаврын улиралд зөвлөсөн оюутны тоо			
3.2 Зөвлөсөн оюутны үнэлгээний голч дүн, сургуулийн үнэлгээний дунгийн голчоос дээш байх	СҮГД-с дээш	35	СҮГД-Сургуулийн үнэлгээний голч дүн
3.3 Захирлын нэрэмжит хуудсанд орсон оюутан		25	
3.4. Тэтгэлэг, тэтгэлэгт хөтөлбарт хамрагдсан оюутан	1 оюутан	15	
3.5. Терийн сангийн зээлд оюутан хамруулсан		10	
3.6. Оюутны ЭШХ-д оюутан удирдаж оролцуулсан		15	
3.7 OXYA-наас зохиосон ажилд оюутан оролцуулсан байдал			
Урлагийн наадам, спортын тэмцээн		10	OXYA-ны тодорхойлолт
Оюутны ёс зүйд чиглэсэн ажил		6	
Мэргэжил сурталчлах үйл ажиллагаа, танин мэдэхүйн лекц	1 оюутан	5	
3.8. Нийтмийн тус түст хөдөлмөрт оюутан хамруулсан байдал			
Эруул мэндийн, олон нийтийн үйлчилгээ	1 оюутан	10	OXYA-ны тодорхойлолт
Нийтмийн тус түст хөдөлмөр		8	
3.9. Оюутны зохион бүтээх ажил удирдсан			
Олон улс, үндэсний хэмжээнд		30	OXYA-ны тодорхойлолт
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд	1 оюутан	25	
Бутээлийн үзэсгэлэнд оюутан хамруулсан		20	
3.10. Олимпиадад оюутан нь амжилт гаргасан			
Олон улс, үндэсний хэмжээнд		20	1-р байр бутэн сноо, 2-р байр 50%, 3-р байр 30%
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд	амжилтаар	10	
3.11. Оюутанд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулсан байдал			
Лекц уншсан	1 ажил	6	OXYA-ны тодорхойлолт
Клуб, дугуйлан удирдсан		10	



ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛЧ БАГШ шалгаруулах үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Авах ондоо	Тайлбар
Нэг. Сургалтын үйл ажиллагаа			
1.1. Олон улсын спортын тэмцээнд амжилттай оролцсон	1 төрөл	50	
1.2. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан			
Гадаад	1 үзэсгэлэн	50	
Дотоод		25	
1.3. Цахим хичээл боловсруулсан	1 иж бүрдэл	10	
1.4. Сургалтанд шинэлэг арга технологи нэвтрүүлсэн	1 хичээл	5	
1.5. Ном сурх бичиг хэвлүүлж, эргэлтэд оруулсан байдал			
Ном, сурх бичиг, дангаараа		3	
хамтарсан		1	
Цахим ном	1 х.х.	2	
1.6. Хянан тохиолдуулсан		1	
1.7. Орчуулгын бүтээл		2	
Номын хэрэглээ, эргэлтэд орсон	1 эргэлт	1	Бүтээл бүр дээр ШУТТНС-н тодорхойлолт
1.8. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар лаборатори байгуулсан	1 лаб	30	
1.9. Мэргэжлийн онцлогийг сурталчлан нээлттэй өдөрлөг зохион байгуулсан	1 ажил	20	
Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, төсөл гэрээт ажил			
2.1. Өгүүлэл хэвлүүлсэн			
IF-тай сэтгүүлд	1 өгүүлэл	10	
Мэргэжлийн хянаагддаг сэтгүүлд		5	
Олон улс, үндэсний хэмжээний хурлын эмхэтгэлд	1 х.х.	6	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хурлын эмхэтгэлд		4	
Олон улс, үндэсний хэмжээний хуралд	1 илтгэл	6	
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хуралд		4	
2.2. Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй	1 эрх	10	
2.3. Шинэ бүтээл, оновчтой саналын гэрчилгээтэй	1 гэрчилгээ	30	
2.4. Өөрийн бүтээлийг сурталчилсан, инновацийн бүтээл нь үйлдвэрлэлд нэвтэрсэн	1 бүтээл	50	
2.5. Удирдсан оюутны бүтээл нь дотоод, гадаадад шалгарсан			
Гадаадад		45	1-р байр бүхэл ондоо, 2-р байр 50%, 3-р байр 30%
Дотоодод	амжилтаар	30	
Гурав. Зөвлөх үйлчилгээ, хувь хүний хөгжил			
3.1. Зөвлөсөн оюутан завсардалгүй сурсан $\frac{ХУЗОТ}{НҮЗОТ} > 0,8$	0,8-аас дээш	40	Сонголт 1,2-ын нэгтгэлээр
энд, НҮЗОТ- Намрын улиралд зөвлөсөн оюутны тоо ХУЗОТ-Хаврын улиралд зөвлөсөн оюутны тоо			
3.2. OXYA-наас зохиосон ажилд оюутан оролцуулсан байдал			
Урлагийн наадам, спортын тэмцээн	1 оюутан	10	OXYA-ны тодорхойлолтоор
Оюутны ёс зүйд чиглэсэн ажил, мэргэжил сурталчлах үйл ажиллагаа, Танин мэдэхүйн лекцэнд оюутан оролцуулсан		10	
3.3. Нийгмийн тус түст хөдөлмөрт оюутнаа хамруулсан байдал			
Эрүүл мэндийн, олон нийтийн үйлчилгээ, байгаль экологийн зориулалттай үйл ажиллагаа ба бусад ижил тестэй ажлууд	1 оюутан	5	OXYA-ны тодорхойлолтоор
3.4. Олимпиад, уралдаанд оюутан нь амжилт гаргасан			
Олон улс, үндэсний хэмжээнд		20	1-р байр бүхэл ондоо, 2-р байр 50%, 3-р байр 30%
Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд	амжилтаар		
3.5. Оюутанд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулсан			
Лекц уншсан	1 оюутан	5	OXYA-ны тодорхойлолтоор
Клуб, дугуйлан удирдсан		10	